



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/133

Арвайхээр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газар 13 дугаар багийн Мэргэд-6 гудамж, 602 тоотод байрлах Д.Цэцэгсүрэн (ЙЮ89011360)-ийн эзэмшил 1063 м² 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай газрыг С.Энхбаяр (ЦГ66080507)-т зориулалтын дагуу 7 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай" 149 дүгээр захирамжийн Д.Цэцэгсүрэнтэй холбогдох хэсэг, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" А/311 дүгээр захирамжийн хавсралтын Д.Цэцэгсүрэнтэй холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0224

D:My Doc. Zahiramj. Zasag darga